# УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 05 ДУГЭЭР САРЫН 30-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГСӨН ҮҮРГИЙН БИЕЛЭЛ

| № | Өгөгдсөн үүрэг, даалгавар | | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага | Биелэлт | хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Танилцуулга: Авлигатай тэмцэх газраас Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх таван ажиллагаа”-ны нэг арга хэмжээ болох “Шүгэл ажиллагаа”-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан соён гэгээрүүлэх “Нэгдье” аяныг улс орон даяар зохион байгуулж байна. Энэхүү аянд байгууллага бүр нэгдэх | Сурталчилгааны постер, шторкийг байгууллагынхаа албан ёсны вэб сайт, фэйсбүүк хуудсаар иргэдэд түгээх | 2023 оны 06 дугаар сарын 25 | Бүх байгууллага | Авлиагатай тэмцэх газраас хэрэгжүүлж буй Шүгэл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “Нэгдье” аянд аймгийн 22 байгууллага нэгдэн өөрсдийн фэйсбүүк хуудсаар сурталчилгааны постер байршуулж иргэдэд түгээн ажилласан. | 90 |
| 2. | | Аймгийн ЗДТГ-аас хуваарилсан самбаруудад сурталчилгааны материалыг өөрсдийн зардлаар гаргаж байршуулах | | | Аймгийн ЗДТГ-аас хуваарилсан самбаруудад сурталчилгааны материалыг 9 байгууллага байршуулж, 9 байгууллага самбарны захиалга өгөн хүлээгдэж байна. | 70 |
| | | Байгууллагынхаа үзүүлж буй үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэх талаар шинийг санаачлан ажиллах | | | Нэгдсэн эмнэлэг амбулаторийн үзлэгийн цагийг E-mongolia, 1800-0119 утсаар авах, цахим өвчний түүх бичих, оношилгоо шинжилгээнд цахимаар илгээх гэх мэт тасгууд хоорондоо цахимаар холбогдож E-health системийг бүрэн нэвтрүүлж эмчилгээ үйлчилгээнд ашиглаж байна.<br>Байгаль орчин, аялал жуулчлалын газар “Та асуу-Бид хариулья үйлчилгээний посторыг цахим хуудсанд тавьж, утсаар зөвөлгөө өгч ажиллаж байна.<br>Сүмбэр сум “ХУРДАН”, Эрх зүйн хөтөч булан шинээр байгуулан иргэдэд үйлчилж байна. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгийн хүрээнд байгууллагууд “Цэвэр цэмцгэр-Говьсүмбэр” аянд нэгдэн байгууллагынхаа гадна талбайн тохижилт болон өөрийн эзэмшил газрынхаа орчны 50м хүртэлх газрын хог хаягдал, зэрлэг ургамал, хуваарьт талбайг цэвэрлэн аянд нэгдэх, Сумдын Засаг дарга нар хэрэгжилтийг хянан, УАШЗөвлөгөөнд тайлагнах | 2023.05.30-2023.09.01-ний өдөр хүртэл | Сумдын Засаг дарга нар | Сүмбэр сумын ЗДТГ 20 байгууллага Шивээговь сумын 5 байгууллага нийтийн эзэмшил газрынхаа орчны 50м хүртэлх газрын хог хаягдал, зэрлэг ургамал, хуваарьт талбайг цэвэрлэсэн талаарх мэдээллийг бэлтгэн танилцуулдаг “Хоггүй Сүмбэр” пэйж хуудсанд тайлагнаж ажилласан бол Шивээговь сумын ерөнхий боловсролын сургуулийн “Эко клуб”-аар дамжуулан иргэд болон суралцагчдад хоггүй цэвэр цэмцгэр байдлыг уриалсан шторк, уриалгуудыг цахим хуудсанд байршуулан, иргэдэд мэдээллэн ажиллаж байна.<br>Баянтал сумын ЗДТГ үүргийн биелэлт ирүүлээгүй. | 70 |
| 5 | ОНХС-ийн цахим санал асуулгыг нэмэгдүүлэхэд анхаарч Тогтвортой амьжиргаа төсөлтэй хамтран ажиллаж үр дүнд хүрэх | 2023.06.15 | Сумдын Засаг дарга нарт | 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний төсөлтэй хамтран цахимаар санал авах ажлын хүрээнд Сүмбэр сум 4 байгууллагын 117 албан хаагчаас Шивээговь сум 1-р багийн 687 иргэн, 2-р багийн 120 иргэнээс саналыг тус тус аваад байна.<br>Баянтал сумын ЗДТГ үүргийн биелэлт ирүүлээгүй | 70 |
| | **Биелэлтийн дундаж хувь** | | | | **74%** |

Үүргийн биелэлт явуулаагүй Баянтал сум ЗДТГ, Хөдөлмөр халамж үйлчилгээний төв,Политехник коллеж,Татварын хэлтэс, Онцгой байдлын газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Нийгмийн даатгалын хэлтэс, Биеийн тамир спортын газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба Шүүхийн шинжилгээний хэлтэс, Улсын бүртгэлийн газар, Авто тээвэр, Цөм сүрэг зэрэг байгууллагууд байна.

Зөвлөмж: 1. Үүргийн биелэлтийг хугацаанд ирүүлэх.
2. Хэрэгжүүлэх арга хэмжээгий үр дүнг тодорхой тайлагнах.

2023 оны 06 дугаар сарын 12-ний өдөр

**Хянасан:** ХШҮ-ний хэлтсийн дарга: М.АНХБАЯР

**Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:**
ХШҮ-ний хэлтсийн мэргэжилтэн Б.МӨНХЗАЯА